



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 20 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 01/278

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”, “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан ТӨБЗГ-2019/XII.1.1.217 дугаар гэрээт Бигэр сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	М.Ууган-Эрдэнэ	-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Бат-Эрдэнэ	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүдэд:	М.Мандахүү	-Архивын тасгийн дарга
	Ж.Мөнхчимэг	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Лхамаа	-Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер
	Б.Хатанболд	-Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер
	Д.Отгонжаргал	-Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч
	Ц.Амарсанаа	-Онцгой байдлын газрын улсын байцаагч, хошууч
	Д.Амгалан	-Боловсрол, соёл урлагийн газрын Санхүү үйлчилгээний албаны дарга
Ш.Лхаасүрэн	-Бигэр сумын Засаг дарга	

2.

Г.Алтанхүү	-Бигэр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал
О.Туяацэцэг	-Бигэр сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багш
Л.Балдорж	-Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
Б.Бээжин	-“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер
Ц.Баярцогт	-“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн инженер
Ч.Нарандэлгэр	-“Барилга байгууламж” ХХК-ийн захирал (Зураг төсөв зохиогч)
Д.Ганзориг	-“Аз өрнөх” ХХК-ийн захирал (гүйцэтгэгч)

2. Барилга, байгууламж, тохижилтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сайтад байршуулахыг комисс (М.Ууган-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, байгууламжийн урсгал засвар, үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгах, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газрын дарга (Р.Батмөнх), Бигэр сумын Засаг даргын Тамгын газар (Ж.Жаргалсайхан)-т, Бигэр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал (Г.Алтанхүү)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

